Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 3126335.9 мянган төгрөгийн 1 хувь буюу 22667.7 мянган төгрөг болж төлөвлөлтийн шатанд тооцсон материаллаг байдлаас 8595.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын суурийг 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаас тооцсон, тайлант жилийн зардал өмнөх оноос өссөнтэй холбоотой байна.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 217868.1 мянган, эцсийн үлдэгдэл 153418. мянган төгрөг болж, өмнөх оноос 64449.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө				
Банканд байгаа бэлэн мөнгө	167,783.90	247,856.40	80,072.50	100%
Орон нутгийн ерөнхий орлого	104,311.3	125,193.9	20,882.60	50.5%
Орон нутгийн хөгжлийн сан	28,960.1	81,128.1	52,168.00	32.7%
Сум хөгжүүлэх сан	34,512.5	41,534.4	7,021.90	16.8%
Замд яваа мөнгөн хөрөнгө				
Хадгаламж				
Дүн	167,783.90	247,856.40	80,072.50	100%

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Оны эцэс дэх нийт мөнгөн хөрөнгийн 50.5 хувийг орон нутгийн ерөнхий орлого, 32.7 хувийг ОНХС-ийн, 16.8 хувийг сум хөгжүүлэх сангийн харилцах дансны эзэлж байна.

Орон нутгийн ерөнхий орлогын дансанд оны эцэст 125193.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэйгээс 40216.3 мянган төгрөг нь оны эхний зарцуулаагүй үлдэгдэл, 25920.8 мянган төгрөг нь оны эцэс төсөвт байгууллагуудаас төвлөрүүлсэн төсвийн хэмнэлт, 25921.3 мянган төгрөг нь төлөвлөгөөнөөс давсан татварын орлогын үлдэгдэл байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 221100.0 мянга, эцсийн үлдэгдэл 241831.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 20731.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	-	86.4	86.4
Байгууллагаас авах авлага	8,000.0	25,808.0	17,808.0
Хувь хүмүүсээс авах авлага	-	7,110.0	7,110.0
Зээлийн авлага	213,100.0	208,827.0	(4,273.0)
Дүн	221,100.0	241,831.4	20,731.4

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Оны эцсийн нийт авлагын 64.7 хувийг сум хөгжүүлэх сан, 27.9 хувийг ОНХС- авлага, 4.1 хувийг сумын ЕБС-ийн байгууллагаас авах авлага эзэлж байна.

Хүснэгт 3. Байгууллагын авлагын үлдэгдэл /мянган төгрөг/

№	Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Ажиллагсадтай холбоотой	Үүнээс:		Зээлийн авлага	Дүнд эзлэх хувь
					Байгууллагаас авах	Хувь хүмүүсээс авах		
1	ИТХ	-	73.7	13.7	-	60.0	-	0.03
2	ЗДТГ	-	7,816.4	18.4	748.0	7,050.0	-	3.21
3	ЕБС	-	9,950.0	-	9,950.0	-	-	4.09
4	ОНХС	68,000.0	68,000.0	-	8,000.0	-	60,000.0	27.93
5	СХС	153,100.0	157,579.6	-	-	-	157,579.6	64.72
6	Соёлын төв	-	54.4	54.4	-	-	-	0.02
	ДҮН	221,100.0	243,474.1	86.5	18,698.0	7,110.0	217,579.6	100.0

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 271446.1 мянган төгрөг байснаас тайлант онд 1778.4 мянган төгрөгөөр нэмэгдэж, оны эцэст бараа материалын үлдэгдэл 273224.5 мянган төгрөг болсон байна.

Хүснэгт №4. Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	2,066.4	5,689.4	3,623.0
Эм боох материал	1,236.4	3,742.5	2,506.1
Дуусаагүй үйлдвэрлэл	45,000.0	-	(45,000.0)
Бичиг хэргийн материал	4,008.1	4,286.8	278.7
Бэлэн бүтээгдэхүүн	-	276.0	276.0
Аж ахуйн материал	4,312.3	7,924.5	3,612.2
Сэлбэг хэрэгсэл	638.6	1,000.0	361.4
Түлш, шатах тослох материал	108.7	1,659.3	1,550.6
Хүнсний материал	5,686.0	919.1	(4,766.9)
Барилгын засварын материал	18,370.0	6,967.5	(11,402.5)
Бусад хангамжийн материал	188,769.5	240,759.3	51,989.8
Мал амьтад	1,250.0	-	(1,250.0)
Дүн	271,446.1	273,224.5	1,778.4

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материал дансны үлдэгдэл өмнөх оноос 1778.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсөвт байгууллагуудад бусад хангамжийн материал нэмэгдсэн, ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 45000.0 мянган төгрөгийн наадмыг талбайг хийж дуусган дуусаагүй үйлдвэрлэл данснаас хасагдсан зэрэгтэй холбоотой байна.

Хүснэгт 5. Байгууллагын бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	ИТХурал	ЗДТГазар	Сургууль	Цэцэрлэг	Соёл	ЭМТөв	ОНХСан	Дүн
Эхний үлдэгдэл	1,736.1	29,120.4	80,673.6	52,782.6	18,916.6	43,216.8	45,000.0	271,446.10
Нэмэгдсэн	10,536.10	64,222.90	54,968.90	43,144.10	2,004.10	68,241.90	0.00	243,118.00
Худалдан авсан	9,515.9	58,839.0	54,968.9	43,034.1	2,004.1	49,718.7		218,080.70
Хандиваар ирсэн	1,020.2	5,383.9		110.0		18,424.1		24,938.20
Бусад						99.1		99.10
Хасагдсан	9,255.80	52,409.06	47,654.80	34,455.24	1,912.70	50,652.00	45,000.00	241,339.60
Худалдсан, зарцуулсан	9,255.8	49,398.8	45,773.4	33,021.9	1,912.7	50,652.0	45,000.0	235,014.60
Шилжүүлсэн		3,010.3	1,881.4	1,433.3				6,325.00
Эцсийн үлдэгдэл	3,016.4	40,934.2	87,987.7	61,471.5	19,008.0	60,806.7	0.0	273,224.50

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 6085041.2 мянга, эцсийн үлдэгдэл 6171911.4 мянган төгрөг болж, 86870.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт №6. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж, орон сууц	4,976,460.6	5,088,782.3	112,321.7
Тээврийн хэрэгсэл	190,930.8	194,694.3	3,763.6
Машин тоног төхөөрөмж	544,349.9	527,155.6	(17,194.2)
Тавилга эд хогшил	170,455.0	192,659.5	22,204.4
Түүх, соёлын дурсгалт зүйлс	1,072.5	1,072.5	0
Номын фонд	57,723.6	60,633.6	2,910.0
Бусад үндсэн хөрөнгө	67,599.8	104,408.6	36,808.7
Программ хангамж	3,637.0	2,505.0	(1,132.0)
Бусад биет бус хөрөнгө	72,812.0	72812.0	0
Дүн	6,085,041.2	6,244,723.3	159,682.1

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 62896.8 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 204567.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бусад байгууллагуудаас шилжүүлэн авч, 77593.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, бусад байгууллагууд руу 29736.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлжээ.

Хүснэгт №7. Байгууллагын үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	ИТХурал	ЗДТГазар	Сургууль	Цэцэрлэг	Соёл	ЭМТөв	Дүн
Эхний үлдэгдэл	8,713.99	3,131,051.13	1,738,899.48	413,841.09	239,382.56	553,153.00	6,085,041.24
Нэмэгдсэн	3,047.50	149,792.96	41,055.25	38,688.40	330.00	34,550.00	267,464.11
Худалдан авсан	2,668.00	11,940.00	37,468.90	7,439.90	330.00	3,050.00	62,896.80
Бусад	379.50	137,852.96	3,586.35	31,248.50	-	31,500.00	204,567.31
	-	-	-	-	-	-	-
Хасагдсан	200.00	1,050.00	67,080.82	9,262.72	-	30,188.43	107,781.98
Акталсан	200.00	1,050.00	67,080.82	9,262.72	-	-	77,593.54
Шилжүүлсэн	-	-	-	-	-	29,736.43	29,736.43
Бусад	-	-	-	-	-	452.00	452.00
Эцсийн үлдэгдэл	11,561.49	3,279,794.09	1,712,873.91	443,266.76	239,712.56	557,514.57	6,244,723.38

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрт урт хугацаат зээл байхгүй, богино хугацаат өр төлбөрийн эхний үлдэгдэл 5266.1 мянга, эцсийн үлдэгдэл 5322.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 56.5 мянган төгрөгөөр өссөн нь ЗДТГ-ын шатахууны өглөг 300.0 мянган төгрөгөөр өссөн, Соёлын төв өмнөх оны 247.3 мянга, ИТХ 18.8 мянган төгрөгийн өглөгийг барагдуулсантай холбоотой байна.

Хүснэгт №8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/

№	Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Ажиллагсадтай холбоотой	Үүнээс:	
					Бараа үйлчилгээний зардлын өглөг	Байгууллагад төлөх
1	ОНХС	5,000.0	5,000.0	0.0	0.0	5,000.0
2	Соёлын төв	247.3	22.6	22.6	0.0	0.0
3	ИТХ	18.8	0.0	0.0	0.0	0.0
4	ЗДТГ	0.0	300.0	0.0	300.0	0.0
	ДҮН	5,266.1	5,322.6	22.6	300.0	5,000.0

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өмнөх оны ОНХС-ийн тайланд бүртгэлтэй 5000.0 мянган төгрөгийн өглөг нь нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн өглөг байна.

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 4706284.6 мянга, эцсийн үлдэгдэл 4791022.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 84737.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №9. Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+/ бууралт /-/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,046,905.1	2,046,905.1	-	42.7
Хуримтлагдсан үр дүн	895,940.9	983,085.0	87,144.1	20.5
Өмнөх үеийн үр дүн	895,940.9	898,347.2	2,406.3	
Тайлант үеийн үр дүн	-	84,737.8	84,737.8	
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,763,438.6	1,761,032.3	(2,406.3)	36.8
Дүн	4,706,284.6	4,791,022.4	84,737.8	100

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 4791022.4 мянган төгрөг болж өмнөх оноос 84737.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5.10 Орлогын данс

Баян-Өндөр сумын ИТХ-ын 2019.12.18-ний өдрийн хуралдааны 12/04 дүгээр тогтоолд зааснаар Баян-Өндөр сумын Засаг дарга тайлант онд улсын төсөвт 3800.0 мянга, аймгийн төсөвт 96500.0 мянга, нийт 100300.0 мянган төгрөгийн орлого оруулахаар батлагдсанаас гүйцэтгэлээр төлөвлөгөөг 115.5 хувиар биелүүлснээс улсын төсөвт төвлөрөх татварын орлогыг 1285.6 мянга, аймгийн төсөвт төвлөрөх татварын орлогыг 8228.4 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт №10. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1.Улсын төсөвт төвлөрүүлэх орлого	3,800.00	5,085.60	1,285.60	133.8
1.1.Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	600	620.3	20.3	103.4
1.2.Нэмэгдсэн өртгийн албан татвар	2,100.00	2,116.30	16.3	100.8
1.3.Агаарын бохирдлын төлбөр	1100	2349	1249	213.5
2.Аймгийн орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого	96,500.00	104,728.40	8,228.40	108.5
2.1.Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар	80,000.00	87,353.00	7353	109.2
2.2.Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар	14000	14633.8	633.8	104.5
2.3.Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	700.00	1,242.50	542.5	177.5
2.4.Газрын төлбөр	1,800.00	1,499.10	-300.9	83.3
Нийт дүн	100,300.00	109,814.00	9,514.00	109.5

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Татварын хэлтсээс ирүүлсэн татварын орлогын мэдээ

Татварын орлогын биелэлтийг нэр төрлөөр нь авч үзвэл газрын төлбөр 300.9 мянган төгрөгөөр тасарч, бусад татварын нэр төрөл тус бүрээр давуулан биелүүлсэн байна.

Сумын ИТХ-ын 2019.12.18-ний өдрийн хуралдааны 12/04 дүгээр тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 76540.0 мянга, хүү торгуулийн орлогыг 4000.0 мянга, нийт 80540.0 мянган төгрөгөөр баталжээ.

Хүснэгт №11. Сумын төсөвт төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1.Татварын орлого	76,540.0	96,505.0	19,965.0	126.08
1.1.ИОТХ	6,500.0	22,237.4	15,737.4	342.11
1.2. Хадгаламжийн хүүгийн орлого	59,000.0	64,377.3	5,377.3	109.11
1.3. Бууны татвар	2,240.0	2,160.0	-80.0	96.43
1.4.Улсын тэмдэгтийн хураамж	1,600.0	1,032.3	-567.7	64.52
1.5.Хог хаягдлын үйлчилгээний төлбөр	6,000.0	4268.5	-1,731.5	71.14
1.6.ҮХЭХ борлуулсны татвар	0	1180.0	1,180.0	
1.7.Газрын төлбөр	1200.0	919.6	-280.4	76.63
1.8. Нохойн татвар	0	330.0	330.0	
2.Татварын бус орлого	4,000.0	9,956.0	5,956	248.91
2.1.Хүү торгуулийн орлого	4000.0	9956.2	5,956.2	248.91
Нийт дүн	80,540.0	106,461.3	25,921.3	132.18

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Татварын хэлтсээс ирүүлсэн татварын орлогын мэдээ

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 19965.0 мянга, хүү торгуулийн орлогыг 5956.0 мянга, нийт 25921.3 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн хэдий ч бууны татвар, хог хаягдлын үйлчилгээний төлбөр, улсын тэмдэгтийн хураамж, газрын төлбөрийн төлөвлөгөөг тасарсан байгаад цаашид анхаарч ажиллах шаардлагатай байна.

ИТОХ-ын төлөвлөгөөг 15737.4 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн нь "Эрдэнэс-тавантолгой" ХК-ийн 2019 оны ногдол ашгийг иргэдийн дансанд төвлөрүүлсний хувь хүний орлогын албан татварыг сумын төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Сумын ИТХ-ын 2019.12.18-ний өдрийн хуралдааны 12/04 дүгээр тогтоолоор сумын ЗДТГ, ерөнхий боловсролын сургуулийн өөрийн орлогыг тус бүр 2000.0 мянган төгрөгөөр

төлөвлөснөөс гүйцэтгэлээр сумын ЗДТГ 1513.0 мянга, ерөнхий боловсролын сургууль 1000.0 мянган төгрөгийн өөрийн орлогыг оруулж, төлөвлөгөөг биелүүлж ажиллажээ.

Дээрх тогтоолоор сум хөгжүүлэх сангаас олгосон зээл, зээлийн хүүгийн орлогоор тайлант онд 72191.0 мянган төгрөгийг оруулахаар баталж, гүйцэтгэлээр 65556.0 мянган төгрөгийг оруулж, төлөвлөгөөг 90.8 хувиар биелүүлсэн байна.

ОНХС-ийн төсөвт хандив тусламжийн орлогоор 30000.0 мянган төгрөг оруулахаар баталсан боловч орлого бүрдээгүй байна.

Соёлын төв өөрийн орлогын төлөвлөгөөгүй бөгөөд гүйцэтгэлээр 1.8 мянган төгрөг оруулжээ.

3.5.11 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71602, 71702, 71801, 71802, 71806, 72101 гэсэн кодтой 9 хөтөлбөрт зориулан 2347640.9 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2128541.0 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас 2009961.0 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулсан бол 118580.0 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд буюу ОНХС-ийн хөрөнгөөс зарцуулсан байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Аймгийн СТСХ-ээс авсан судалгаагаар тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны 5 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн байхад сумын Эрүүл мэндийн төв төсвийн төслийг хүргүүлээгүй ба аймгийн ИТХТ-ын 2019.11.29-ний өдрийн 18/16 дугаар тогтоолоор нийт 2463991.0 мянган төгрөгийн төсөв баталсан байна.

Байгууллагын нэр	Төсвийн төсөл	Анх батлагдсан
ИТХ	84,219.8	69,232.1
ЗДТГ	378,119.0	411,500.2
ЭМТ		388,386.3
ЕБС	752,559.3	851,686.7
Цэцэрлэг	277,245.2	307,006.3
Соёлын төв	98,871.2	85,201.7
ОНХС		278,786.7
СХС		72,191.0
Дүн	1,591,014.4	2,463,991.0

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын 2019.12.18-ний өдрийн 12/04 дүгээр тогтоолоор анх баталсан 2463991.0 мянган төгрөгийг сумын ИТХ-ын хуралдааны 2020.11.04-ний өдрийн 01/08 дугаар тогтоолоор 61214.7 мянган төгрөгөөр бууруулж, ЕБС, Цэцэрлэгийн төсвийг аймгийн Засаг даргын 2020.10.27-ний өдрийн А/770 дугаар захирамжаар 5050.9 мянган төгрөгөөр, 2020.12.31-ний өдрийн А/850 дугаар захирамжаар 50084.5 мянган төгрөгөөр бууруулснаар сумын нийт төсөв 2347640.9 мянган төгрөг болжээ.

Нийт зардлын 1302057.5 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс, 26664.7 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох санхүүжилтээс, 200964.2 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 569128.5 мянган төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, 80540.0 мянган төгрөгийг сумын орон нутгийн төсвөөс, 74191.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны

орлогоос, 64095.0 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс, 30000.0 мянган төгрөгийг хандивын орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт, орон нутгийн төсвөөс авах санхүүжилтийг бүрэн авч, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтийг 105584.2 мянга, Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох санхүүжилтээс 704.1 мянган төгрөгийн санхүүжилт дутуу авсан байна.

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Засаг даргын Тамгын газар	406,700.2	383,603.9	23,096.3	94.3
Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	67,860.0	65,667.0	2,193.0	96.8
Ерөнхий боловсролын сургууль	815,170.8	793,824.2	21,346.6	97.4
Цэцэрлэг	261,566.7	256,334.2	5,232.5	98.0
Эрүүл мэндийн төв	388,386.3	377,709.5	10,676.8	97.3
Соёлын төв	81,601.7	74,290.1	7,311.6	91.0
Орон нутгийн хөгжлийн сан	254,164.2	118,580.0	135,584.2	46.7
Сум хөгжүүлэх сан	72,191.0	58,534.1	13,657.0	81.1
Нийт дүн	2,347,640.9	2,128,542.8	219,098.1	90.7

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2128542.8 мянган төгрөг буюу 90.7 хувьтай байгаа нь ОНХС-ийн төлөвлөсөн зардлыг 135584.2 мянган төгрөгөөр дутуу олгосон, бараа үйлчилгээний зардлыг 8935.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 18475.9 мянга, цалингийн зардлыг 13128.7 мянган төгрөгөөр хэмнэгдсэн, ОНХС-аас авах санхүүжилтийг дутуу авснаас 135584.2 мянган төгрөгийн төсөл арга хэмжээ хэрэгжээгүй зэрэг нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

Хүснэгт 12. Баян-Өндөр сумын Засаг даргын төсвийн гүйцэтгэл, хөтөлбөрөөр /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,347,640.90	2,128,542.82	219,098.08	90.7
70105 ОН-ын өөрөө удирд ёсны байгууллага	67,860.00	65,667.00	2,193.00	96.8
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	56,418.00	54,806.90	1,611.10	97.1
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	900.00	665.30	234.70	73.9
80825 Багийн ИНХ-ын дарны урамшуулал	10,542.00	10,194.80	347.20	96.7
82201 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардал	-	-	-	-
70106 ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага	406,700.20	383,603.90	23,096.30	94.3
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	318,498.90	303,263.90	15,235.00	95.2
80106 Баг, хорооны ҮАЗардал	55,970.30	51,065.30	4,905.00	91.2
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	1,000.00	200.00	800.00	20.0
81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	21,000.00	20,840.70	159.30	99.2
82212 Хур хог хаягдал, орчны бохирдол	6,000.00	4,003.00	1,997.00	66.7
83201 Ангилалдаагүй бусад зориулалт	4,231.00	4,231.00	-	100.0
70503 Орон нутгийн зорилтот ХОруулалт	254,164.20	118,580.00	135,584.20	46.7
80904 Нийгмийн зориулалттай барилга	254,164.20	118,580.00	135,584.20	46.7
71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ	388,386.30	377,710.48	10,675.82	97.3
80109 ТЗШ-ийн бга-уудын тогтмол зардал	18,591.90	17,491.61	1,100.29	94.1
80302 Нэг иргэнд ногдох нормативаар	22,539.40	17,179.03	5,360.37	76.2
81603 үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ	347,255.00	343,039.84	4,215.16	98.8
71801 Сургуулийн өмнөх боловсрол	261,566.70	256,334.90	5,231.80	98.0
80103 Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	-	-	-	-
80109 ТЗШ-ийн бга-уудын тогтмол зардал	24,652.20	24,159.70	492.50	98.0
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	133.10	133.00	0.10	99.9
81807 Цэцэрлэгийн хүүхдийн хоол	18,750.60	18,749.90	0.70	100.0
81834 Боловсролын стандарт, сургалт	183,466.70	181,789.00	1,677.70	99.1
81832 Нүүдлийн бүлэгт хамруулах	3,022.50	3,022.50	-	100.0
81833 Явуулын багшийн үйлчилгээ	3,286.50	3,279.80	6.70	99.8
81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	28,255.10	25,201.00	3,054.10	89.2
71802 Ерөнхий боловсрол	805,274.10	784,271.29	21,002.81	97.4
80103 Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	-	-	-	-

Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

80109 ТЗШ-ийн бга-уудын тогтмол зардал	92,157.50	91,096.60	1,060.90	98.8
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж	1,630.00	1,617.60	12.40	99.2
81801 үдийн цай хөтөлбөр	18,920.10	11,382.30	7,537.80	60.2
81806 Дотуур байрны үйлчилгээ	77,476.60	71,282.60	6,194.00	92.0
81834 Боловсролын стандарт, сургалт	464,528.40	459,329.13	5,199.27	98.9
81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	150,561.50	149,563.06	998.44	99.3
71806 Насан туршийн болон албан бус боловсрол	9,896.70	9,552.90	343.80	96.5
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	9,896.70	9,552.90	343.80	96.5
72101 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	72,191.00	58,534.05	13,656.95	81.1
82611 Жижиг дунд үйлдвэрийг дэмжих	72,191.00	58,534.05	13,656.95	81.1
71702 Соёл урлаг	81,601.70	74,288.30	7,313.40	91.0
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	73764	68434.4	5329.6	92.8
80214 Уран бүтээл хийлгэх	1,983.80		1983.8	0.0
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	5853.9	5853.9	0	100.0

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчаас 86004.9 мянган төгрөгийн нэмэлт бүрдүүлж бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжид 39260.6 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулагдаагүй үлдэгдлийн 26911.1 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Байгууллагын нэр	Санхүүжилт	Зарцуулалт	Төвлөрүүлсэн	
			Аймаг	Сум
Засаг даргын Тамгын газар	30,306.68	11,208.86	19,097.82	
Ерөнхий боловсролын сургууль	22,224.46	17,674.96	4,549.50	
Эрүүл мэндийн төв	5,263.80	2,000.00	3,263.80	
Цэцэрлэг	28,209.97	28,209.97	-	
Нийт дүн	86,004.91	59,093.79	26,911.12	-

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 157 мэдээллээс 151 мэдээллийг хугацаанд нь, 6 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Хүснэгт 13. Шилэн дансны мэдээлэл

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд нь мэдээлсэн	Хугацаа хоцроосон	Хоцроосон мэдээлэл
1	Бүтэн жил	14	14	12	2	Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө
2	Хагас жил	3	3	3	0	
3	Улирал бүр	2	8	7	1	2 дугаар улирлын улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл
4	Сар бүр	5	60	58	2	10 дугаар сарын улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл ба хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбар
5	Тухай бүр	6	72	71	1	10 дугаар сарын тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт
	Нийт	30	157	151	6	

Эх сурвалж. Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын шилэн дансны цахим хуудас

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг ахлах аудитор Б.Азбаяр гүйцэтгэж, менежментийн захидлаар 2 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, “Төсвийн шууд захирагчийн тайланг Сангийн яамны “Э-Тайлан”-нд шивэхдээ Төрийн сангийн хэлбэлзэл, аудитлагдсан санхүүгийн тайлантай тулгаж, үнэн зөв шивж буй эсэхэд хяналт тавьж ажиллах” зөвлөмж хэрэгжээгүй ба тайлант онд сумын санхүүгийн албаны дарга шинээр томилогдсон нь нөлөөлсөн байна.

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Баян-Өндөр сумын Засаг даргын үр дүн, мөнгөн гүйлгээний тайлангийн эхний үлдэгдэл өмнөх оны аудитлагдсан тайлангаас 704555.2 мянган төгрөгөөр зөрүүтэй, нэмэлт санхүүжилтийн тайланд өмнөх оны нэмэлт санхүүжилтийн тайланг тусгаагүй зөрчлийг аудитын явцад залруулсан ба цаашид Засаг даргын нэгтгэсэн тайлангийн эхний үлдэгдлийг үнэн зөв тайлагнаж, төрийн аудитын байгууллагад үнэн зөв, бүрэн илэрхийлсэн санхүүгийн тайланг ирүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн эхний, эцсийн үлдэгдлийг аудитлагдсан санхүүгийн тайлантай тулган шалгахад нэгтгэсэн тайланд харьяа байгууллагуудын аудитлагдсан санхүүгийн тайлангаар нэгтгээгүй, Э-тайланд орлого, зардлыг бөөн дүнгээр оруулсан, дансны ангилал зөрүүтэй оруулсан зэргээс шалтгаалж, аудитын явцад 76052.2 мянган төгрөгийн алдаа илэрснээс үр дүнгийн тайланд 31675.1 мянга, мөнгөн гүйлгээний тайланд 32739.0 мянга, төсвийн гүйцэтгэлийн тайланд 2386.3 мянга, нэмэлт санхүүжилтийн тайланд 8951.8 мянга, бараа материалын тодруулга тайланд 300.0 мянган төгрөгийн алдааг залруулав.

№	Байгууллагын нэр	Үр дүнгийн тайлан	Мөнгөн гүйлгээний тайлан	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Нэмэлт санхүүжилтийн тайлан	Бараа материалын тодруулга	Дүн
1	Засаг даргын Тамгын газар	29,506.1	29,789.0			300.0	59,595.1
2	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	2,169.0	2,950.0	-	1,200.0		6,319.0
3	Ерөнхий боловсролын сургууль			2,384.1			2,384.1
4	Эрүүл мэндийн төв			0.4	3,201.8		3,202.2
5	Цэцэрлэг				1,000.0		1,000.0
6	Соёлын төв			1.8	3,550.0		3,551.8
	Дүн	31,675.1	32,739.0	2,386.3	8,951.8	300.0	76,052.2

Төсвийн гүйцэтгэлийн тайланд гарсан алдааны дийлэнх хувь нь өмнөх оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг зөрүүтэй оруулсан ба дээрх алдаанаас гадна төсвийн гүйцэтгэлийн тайланд байгууллагын ажиллагсдын болон сурагчдын тоог аудитын тайлангаас зөрүүтэй оруулсан алдаа гарсныг аудитын явцад Э-тайлангийн тоогоор залруулав.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

Сумын ОНХС-ийн санхүүгийн тайланд бүртгэсэн 2019 онд үүссэн сумын Цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын зургийн үнийн 8000.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 39 дүгээр зүйлийн 39.4.2 дахь “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 61.1-д заасан чиг үүргийг төлөөлөн хэрэгжүүлэхэд дараах шаардлага тавигдана: өр, авлага үүсгэхгүй байх” гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: "Дөрвөн гүн" ХХК-аар 8000.0 мянган төгрөгийг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

Төвлөрүүлэн захирагчид 574270.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 2 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгайн сангийн нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 7 байгууллага аудитад хамрагдаж, сумын ИТХ-д итгэл үзүүлсэн байна.

№	Байгууллагын нэр	Аудит хийсэн байгууллагын нэр	Дүгнэлтийн хэлбэр
1	Засаг даргын Тамгын газар	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар	Зөрчилгүй
2	Ерөнхий боловсролын сургууль		Зөрчилгүй
3	Эрүүл мэндийн төв	"Глобал капитал аудит" ХХК	Зөрчилгүй
4	Цэцэрлэг		Зөрчилгүй
5	Иргэдийн төлөөлөгчийн хурал	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар	Итгэл үзүүлсэн
6	Соёлын төв		Түүвэрт хамрагдсан
7	Орон нутгийн хөгжлийн сан		Түүвэрт хамрагдсан
8	Сум хөгжүүлэх сан		Түүвэрт хамрагдсан

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар 3 төсвийн байгууллагад нийт 3535.0 мянган төгрөгийн 10 алдаа, зөрчил илрүүлснээс 2508.0 мянган төгрөгийн 3 алдааг аудитын явцад залруулж, 60.0 төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 967.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 6 зөвлөмжийг хүргүүлжээ.

Үзүүлэлт	ЗДТГ	Эрүүл мэндийн төв	Ерөнхий боловсролын сургууль	Дүн
Төлбөрийн акт	тоо	1	0	1
	дүн	60.0	0	60.0
Зөвлөмж	тоо	3	2	6
	дүн	967.0	0	967.0
Залруулга	тоо	3		3
	дүн	2508		2508
Нийт алдаа зөрчил	тоо	7	2	10
	дүн	3535.0	0	3535.0

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Санхүүгийн тайлангийн завсрын аудитаар Э-тайлангийн эхний үлдэгдэл нь санхүүгийн тайлан гаргаж байгаа Acolous программын эхний үлдэгдэлтэй тохирч байгаа эсэхийг тулган баталгаажуулсан эсэхийг шалгах шаардлагатай байна.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

3.1.1. **Илрүүлэлт:** Төсөвт байгууллага, сангийн нягтлан бодогч нар Сангийн яамны Э-тайланд санхүүгийн тайлангийн орлого, зарлагын төрлийг санхүүгийн тайлангаас 76052.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байхад сумын санхүүгийн албаны дарга хяналт тавьж ажиллаагүй байна.

Энэ нь Үнэн зөв байдал, Хэмжилт гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 55 дугаар тушаалыг тус тус зөрчсөн байна.

3.1.2. Эрсдэл: Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн материаллаг хэмжээний алдаа зөрчлийн дүн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хүлээн зөвшөөрөгдөх материаллаг байдлаас хэтэрсэн байх.

3.1.3 Өгсөн зөвлөмж: Сумын төсөвт байгууллагуудын санхүүгийн тайлангийн үнэн зөв гаргасан байдал, аудитлагдсан санхүүгийн тайланг Сангийн яамны Э-тайланд орлого, зарлагыг данс бүрээр тайлагнаж байгаад тавих санхүүгийн албаны даргын хяналтыг сайжруулах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

3.2. УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

3.2.1. Илрүүлэлт: Сум хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл авсан 11 зээлдэгч 30350.0 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүгийн орлогыг төлөөгүй хугацаа хэтрүүлж, оны эцэст хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй байхад хяналт тавьж, хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлээгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 4.7 дахь Иргэн, хуулийн этгээд авсан зээл, зээлийн хүүг гэрээнд заасан хугацаанд сангийн дансанд буцаан төлнө” заалтыг зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл: Сангийн хөрөнгөөс олгосон зээл гэрээнд заасан хугацаанд төлөгдөхгүй сан хохирох, дараагийн зээлдэгч сангаас зээл авах боломжгүй болох.

3.2.3 Өгсөн зөвлөмж: Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөс хөнгөлөлттэй зээл авч хугацаандаа төлөөгүй 11 зээлдэгчийн 30350.0 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүг 2021 оны 06 дугаар сарын 25-ны дотор төлүүлэх арга хэмжээ авч, заасан хугацаанд төлөөгүй иргэдийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэх.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

3.3. УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

3.2.2 Илрүүлэлт: Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс шилэн дансны цахим хуудаст тайлант хугацаанд мэдээлбэл зохих 157 мэдээллээс 151 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 6 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх “Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх зарчмыг баримтална” гэснийг зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл: Төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоо бүрдүүлэхгүй байх.

3.2.3 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хугацаанд нь бүрэн байршуулах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 06 дугаар сарын 25-ний дотор нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

Бэлтгэсэн:
АХЛАХ АУДИТОР

Анхан шатанд хянасан:
АУДИТЫН МЕНЕЖЕР

Хоёр дахь шатанд хянасан:
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ДОЛЖМАА 2021.03.25

А.ЦЭЭНЯМ 2021.03.25

Б.МӨНХБАТ 2021.03.25

5. Хавсралт 1. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо	Аудитын нэр:	Баян-Өндөр сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит		Аудитын код:	
2021.03.25				БНА-2021/4/СТА-ТТ3	
Шалгагдсан байгууллагын нэр:		Баян-Өндөр сумын Засаг дарга		Мянган төгрөг	
№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1.Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайлан					
1	Сумын ОНХС-ийн санхүүгийн тайланд бүртгэсэн 2019 онд үүссэн сумын Цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын зургийн үнийн 8000.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна.	8000.0	Төлбөрийн акт тогтоосон.	Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга	Б.Идэрмөнх, Г.Дүүрэнбилэг
2	Төсөвт байгууллага, сангийн нягтлан бодогч нар Сангийн яамны Э-тайланд орлого, зарлагын төрлийг санхүүгийн тайлангаас 574270.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байхад сумын санхүүгийн албаны дарга хяналт тавьж ажиллаагүй байна.	574270.0	Зөвлөмж өгсөн.	Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга	Б.Идэрмөнх, Г.Дүүрэнбилэг
3	Сум хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл авсан 11 зээлдэгч 30350.0 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүгийн орлогыг төлөөгүй хугацаа хэтрүүлж, оны эцэст хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй байхад хяналт тавьж, хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлээгүй байна.	30350.0	Зөвлөмж өгсөн.	Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга	Б.Идэрмөнх, Г.Дүүрэнбилэг
4	Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс шилэн дансны хуудаст 6 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	0	Зөвлөмж өгсөн.	Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга	Б.Идэрмөнх, Г.Дүүрэнбилэг
Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайлангийн алдааны дүн		612620.0			
Харьяа төсвийн байгууллагуудын дүн					
Ерөнхий боловсролын сургууль					
1	Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс Шилэн дансны мэдээллийн Төсөв, гүйцэтгэл талбарт сар бүр оруулах 1, тухай бүр оруулах 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.	0	Зөвлөмж өгсөн	Дарга, нягтлан бодогч	Д.Цэцэгжаргал, З.Саранчулуун
ДҮН		0			
Засаг даргын Тамгын газар					
2	Баян-Өндөр сумын хил хамгаалалтад туслах хүчний орон тооны бус зөвлөлөөс 2020 онд хийх ажлын төлөвлөгөөний дагуу хилийн 0166 дугаар ангид хилийн манааны уналгын 2000.0 мянган төгрөгийн өртөгтэй мотоцикл өгснийг үндсэн хөрөнгөндөө бүртгэж аваагүй.	2,000.0	Санхүүгийн тайланд залруулсан	Дарга, нягтлан бодогч	Э.Амгаланбаяр, Т.Уянга
3	Тайлант хугацаанд түлш шатахуун бэлтгэн нийлүүлэгч НИК ХХК-д 208.0 мянган төгрөг илүү шилжүүлсэн ч авлагаар тусгаагүй.	208.0	Санхүүгийн тайланд залруулсан	Дарга, нягтлан бодогч	Э.Амгаланбаяр, Т.Уянга
4	Тайлант хугацаанд иргэн М.Жаргалсайханаас худалдан авсан шатахууны үнийг 300.0 мянган төгрөг дутуу шилжүүлсэн байхад санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй.	300.0	Санхүүгийн тайланд залруулсан	Дарга, нягтлан бодогч	Э.Амгаланбаяр, Т.Уянга
5	Тус байгууллагын тохижилт үйлчилгээний ажилтан А.Амартүвшиний урамшуулалт	60.0	Төлбөрийн акт тогтоосон	Дарга, нягтлан бодогч	Э.Амгаланбаяр, Т.Уянга

**Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

	цалинг 2020 оны 10, 11 дүгээр саруудад тус бүр 30000 төгрөгөөр илүү олгосон.				
6	Тус байгууллагын программ хангамжийн дансанд 385.0 мянган төгрөгийн үнэ бүхий төрийн сангийн программ нь ашиглалтгүй байна.	385.0	Зөвлөмж өгсөн	Дарга, нягтлан бодогч	Э.Амгаланбаяр, Т.Уянга
7	Тайлант хугацаанд тээвэр шатахууны зардлаас 582.0 мянган төгрөгийн бичиг хэргийн материалын үнэ шилжүүлж журмыг зөрчсөн	582.0	Зөвлөмж өгсөн	Дарга, нягтлан бодогч	Э.Амгаланбаяр, Т.Уянга
8	Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 151 мэдээлэл оруулахаас сар бүр болон тухай бүр оруулах батлагдсан төсөв гүйцэтгэл, батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт, хөрөнгө оруулалт, тендерийн ерөнхий мэдээлэл, төсөв, өмч хөрөнгө зарцуулахтай холбоотой шийдвэр зэрэг нийт 15978.3 мянган төгрөгийн 7 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.	0.0	Зөвлөмж өгсөн	Дарга, нягтлан бодогч	Э.Амгаланбаяр, Т.Уянга
	ДҮН	3535.0			
Эрүүл мэндийн төв					
9	Шилэн дансны сайтад давхардсан тоогоор нийт 151 мэдээлэл байршуулахаас 144 мэдээллээс бүтэн жилээр байршуулах 2 төрлийн 2 мэдээлэл, сараар байршуулах 2 төрлийн 2 мэдээлэл, тухай бүр байршуулах нийт 2 төрлийн 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.	0	Зөвлөмж өгсөн	Дарга, нягтлан бодогч	Э.Амгаланбаяр, Т.Уянга
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж мөрдөж ажиллах зөвлөмжийг 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн байхад бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.	0	Зөвлөмж өгсөн	Дарга, нягтлан бодогч	Б.Пүрэвжаргал, Т.Болорцэцэг
	ДҮН	0			
	Төсвийн шууд захирагчийн тайлангийн алдааны дүн	3538.0			

---oOo---